

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2015.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0004	Хувилбар: 2.0

ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (БОНУА)

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
1.	Биологийн төрөл зүйлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө (БТЗУАТ)	<p>ОТ ХХК нь БТЗУАТ-д тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах болон бусад арга хэмжээг тус төлөвлөгөөнд заасан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>ОТ ХХК БТЗУАТ-ний хэрэгжилтийн явцын талаар санхүүжүүлэгчдэд тайлагнана.</p>	БТЗУАТ-г тус төлөвлөгөөнд заасан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ. Улирал бүр Санхүүжүүлэгчдэд тайлагнана.
2.	Цахилгаан станцын Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)	<p>Санхүүжүүлэгчийн журамд Цахилгаан станцыг Төслийн нэгээхэн хэсэг гэж заасанчлан, ОТ ХХК Цахилгаан станцын БОННУ-г Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бие даасан аудиторт (БОННБДА) Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан хугацаанд хүргүүлнэ. Энэхүү Цахилгаан станцын БОННУ-г холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандарт болон Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хууль тогтоомжийн¹ дагуу хийж гүйцэтгэнэ. БОННБДА нь тухайн Цахилгаан станцын БОННУ-ний бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангасан тохиолдолд ОТ ХХК-д баталгаажуулж мэдэгдэнэ².</p> <p>ОТ ХХК Цахилгаан станцын БОННУ-г холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу олон нийтэд мэдээлнэ.</p> <p>ОТ ХХК нь (i) ОТ уурхай болон гуравдагч талын цахилгаан станцын хооронд дамжуулах шугам байгуулах санал гарсан бол түүний Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг (Цахилгаан дамжуулах шугамын БОННУ) Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бие даасан аудиторт хүргүүлэх, (ii) тухайн дамжуулах шугамд хамааралтай Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн стандарт болон холбогдох байгаль орчин, нийгмийн хуулиудад нийцүүлэн³ Дамжуулах шугамын БОННУ-г боловсруулахад өөрийн зүгээс боломжит зүйлсийг хийнэ. БОННБДА нь Цахилгаан дамжуулах шугамын БОННУ нь холбогдох Санхүүжэгчийн байгаль орчин, нийгмийн стандартад⁴ бүрэн нийцэж байгаа эсэхийг ОТ ХХК-д мэдэгдэх бөгөөд ОТ ХХК-аас уг Цахилгаан дамжуулах шугамын БОННУ-г холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн стандартад нийцүүлэхэд чиглэж</p>	<p>ОТ ХХК нь БОННБДА-ын баталсан Цахилгаан станцын БОННУ-нд заасан газарт барилгын үйл ажиллагаа эхлүүлэхээс дор хаяж 60 хоногийн өмнө Цахилгаан станцын БОННУ-г олон нийтэд мэдээлж, танилцуулна.</p> <p>ОТ ХХК нь Цахилгаан дамжуулах шугам болон Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ тус бүрт заасан газарт барилгын үйл ажиллагаа эхлүүлэхээс дор хаяж 60 хоногийн өмнө Цахилгаан дамжуулах шугам болон Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ-г олон нийтэд мэдээлж, танилцуулахад чиглэж өөрийн зүгээс боломжит нөлөөллийг үзүүлнэ.</p>

¹ Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны” холбогдох хууль тогтоомжуудыг Цахилгаан станцын БОННУ-ний холбогдох хууль тогтоомжийн жагсаалт гэсэн хэсэгт зааж өгнө.

² Уг зорилгоор хамааралтай Зээлдүүлэгчийн байгаль орчны болон нийгмийн стандартыг Цахилгаан станцын БОННУ-г гаргах үед тохиролцсон, Цахилгаан станцын БОННУ-д тусгасан гүйцэтгэлийн стандартаас тодорхойлно.

³ Холбогдох “Байгаль орчин, нийгмийн хууль”-ийг Цахилгаан дамжуулах шугамын БОННУ боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Цахилгаан дамжуулах шугамын БОННУ-д зааж өгсөн жагсаалтаар тодорхойлно.

⁴ Холбогдох “Байгаль орчин, нийгмийн хууль”-ийг Цахилгаан дамжуулах шугамын БОННУ боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Цахилгаан дамжуулах шугамын БОННУ-д зааж өгсөн жагсаалтаар тодорхойлно.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2015.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0004	Хувилбар: 2.0

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
		<p>өөрийн зүгээс боломжит нөлөөллийг үзүүлнэ.</p> <p>Мөн ОТ ХХК нь (i) Гуравдагч талын цахилгаан станц байгуулах санал гарсан бол түүний Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг (Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ) Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн бие даасан аудиторт хүргүүлэх, (ii) Гуравдагч талын цахилгаан станцад хамааралтай Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн стандарт болон холбогдох байгаль орчин, нийгмийн хуулиудад нийцүүлэн⁵ Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ-г боловсруулахад өөрийн зүгээс боломжит нөлөөллийг үзүүлнэ. БОННБДА нь Гуравдагч талын цахилгаан дамжуулах шугамын БОННУ нь холбогдох Санхүүжэгчийн байгаль орчин, нийгмийн стандартад⁶ бүрэн нийцэж байгаа эсэхийг ОТ ХХК-д мэдэгдэх бөгөөд ОТ ХХК-аас уг Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ-г холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн стандартад нийцүүлэхэд чиглэж өөрийн зүгээс боломжит нөлөөллийг үзүүлнэ.</p>	
7.	Бэлчээрийн менежмент ба амьжиргааг сайжруулах стратеги	<p><i>ОТ ХХК Бэлчээрийн менежмент ба амьжиргааг сайжруулах стратегийг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу БОННБДА-т хүргүүлнэ. Бэлчээрийн менежмент ба амьжиргаа сайжруулах стратегийг дараах байдлаар боловсруулахаар төлөвлөсөн болно: (i) хэрэгжилтийн үр дүнг хянах үндсэн Гүйцэтгэлийн үзүүлэлтийг оруулах, (ii) орон нутгийн оролцогч талууд, орон нутгийн гишүүд болон Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах стратегийг зохиож, хэрэгжүүлэхэд оролцсон мэргэжилтнүүдтэй зөвшилцөж боловсруулах, (iii) Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах стратеги болон БТЗУАТ-ний зорилготой нийцсэн загвартай байх.</i></p> <p><i>БОННБДА нь Бэлчээрийн менежмент ба амьжиргаа сайжруулах стратегийн бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагуудтай нийцсэн тохиолдолд баталгаажуулж, ОТ ХХК-д мэдээлнэ.</i></p> <p>Бэлчээрийн менежментийг сайжруулах стратегийг үндэслэн, ОТ ХХК Бэлчээрийн менежментийг сайжруулах төлөвлөгөөг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу БОННБДА-т хүргүүлнэ. Бэлчээрийн менежментийг сайжруулах төлөвлөгөө гэдэг нь дараах зүйлсийг нэгтгэн оруулсан нарийвчилсан менежментийн төлөвлөгөө юм. Үүнд (i) шинэчилсэн Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний бүх шаардлагатай хэсгүүдийг нэгтгэх, ii) Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөөний бүх шаардлагатай хэсгүүдийг нэгтгэн оруулах, (iii)</p>	<p>Ташуугаар бичсэн арга хэмжээнүүд ДУУССАН</p> <p>Төлөвлөгөөний төслийг 2016 оны 3 дугаар улиралд илгээнэ</p>

⁵ Холбогдох “Байгаль орчин, нийгмийн хууль”-ийг Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ-д зааж өгсөн жагсаалтаар тодорхойлно.

⁶ Холбогдох “Байгаль орчин, нийгмийн хууль”-ийг Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ боловсруулах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Гуравдагч талын цахилгаан станцын БОННУ-д зааж өгсөн жагсаалтаар тодорхойлно.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2015.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0004	Хувилбар: 2.0

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
		нэн чухал экосистемийн үйлчилгээ болон амьжиргаа сайжруулах хөтөлбөрийн мониторинг, үнэлгээний хөтөлбөрт нэгтгэн оруулах, мөн (iv) ОТ ХХК-ийн хэмжээнд хэрэгжилтийн болон мониторингийн арга барилыг нэгтгэсэн байгаль орчин болон нийгмийн үйл ажиллагааны баг ажиллуулах.	
8.	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн тайлан	<p>ОТ ХХК Санхүүжүүлэгчийн байгаль орчин нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг хоногт тооцоогоор 100,000 тонноос дээш хэмжээнд хүргэх аливаа өргөтгөлийн ажил болон түүнээс хойш хийгдэх томоохон өргөтгөлийн ажлуудыг хянуулах буюу мэдээлэх зорилгоор (шаардлагатай тохиолдолд) Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн тайлан боловсруулж БОННБДА-т хүргүүлнэ. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн тайланд энэхүү хийхээр төлөвлөсөн өргөтгөлтэй холбоотой гарах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон ОТ компанийн мэдэлд байгаа баримт бичгийг дэлгэрэнгүй байдлаар тусгаж өгнө:</p> <ul style="list-style-type: none"> a) өргөтгөлийн ажилтай холбогдуулан усыг нөхөн сэргээх боломжуудыг нэмэгдүүлэх мөн нэмэлт гүний усны шахалтыг багасгах зорилгоор усыг дахин ашиглах; b) өргөтгөл хийхэд шаардлагатай нэмэлт усны хангамж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор зохих гидрогеологийн судалгааг хийх бөгөөд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжүүлэлтийг харгалзаж үзсэний дараа нэмэлт усны олборлолт нь (жишээ нь: биологийн төрөл зүйл, малчид) тухайн нэмэлт усны ашиглагчдад ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй байх; c) МУ-ын Засгийн газраас шаардлагатай нэмэлт гүний ус ашиглах зөвшөөрлийг авсан байх эсвэл тухайн зөвшөөрлийг авах өргөдөл гаргасан байна; d) Өргөтгөлийн ажлаас үүдэн тээврийн хэрэгслийн ачаалал нэмэгдсэнтэй холбогдуулан биологийн төрөл зүйл болон нийгмийн нөлөөллийг үнэлсэн байх: болон e) Өргөтгөлтэй холбоотой нийт гарах нөлөөг үнэлэх.. <p>БОННБДА нь Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн төслийн бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагуудтай нийцсэн тохиолдолд баталгаажуулна. Баяжуулах үйлдвэрийн тайланд холбогдох Ашиглалтын үе шатны Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө хянан засварлах ажил хамаарч болно.</p>	ОТ ХХК Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн тайланг хүргүүлж, БОННБДА-с шаардлагатай баталгаажуулалтыг Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн тайланд заасан талбайд баяжуулах үйлдвэрийн барилгын ажил эхлэхээс 60 хоногийн өмнө авна.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2015.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0004	Хувилбар: 2.0

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
9.	Бие даасан Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн мониторингийн хөтөлбөр	<p>ОТ ХХК Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн мониторингийн гуравдагч этгээдийн бие даасан хөтөлбөрийг боловсруулж, Ажлын удирдамжийг хүргүүлэн Санхүүжүүлэгчээр батлуулна.</p> <p>Зээлдүүлэгчид бие даасан Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн мониторингийн хөтөлбөрийн бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагуудтай нийцсэн тохиолдолд баталгаажуулна.</p> <p>Ажлын удирдамжийн шаардлагын дагуу БОННБДА нь ОТ ХХК-ийн зардлаар тогтмол хяналт шалгалт хийж, олон нийтэд мэдээлэх, ерөнхий тойм болон үл нийцлийг багтаасан мониторингийн тайланг боловсруулах (Санхүүжүүлэгч болон ОТ ХХК-иар хянуулж, зөвлөмж авсны дараа) юм. Уг мониторингт БОНУАМТ болон БОНУА хэрэгжүүлэх ажил орно.</p>	<p>Ташуу бичсэн арга хэмжээнүүд ДУУССАН</p> <p>ХИЙГДЭЖ БАЙНА</p>
10.	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн тайлангууд	ОТ ХХК жил бүрийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн тайланг боловсруулж, тохиролцсон хэлбэрээр Санхүүжүүлэгчид хүргүүлнэ. Үүнд БОНУАМТ болон БОНУА-н хэрэгжүүлэлтийн тайлан орно.	Жил тутам
14.	Нэмэлт дэд бүтэц хөгжүүлэлт (тухайлбал орон сууц, үйлдвэрлэлийн байгууламж)	<p>ОТ ХХК-аас санхүүжүүлэх, эсвэл ажиллуулах бүх нэмэлт дэд бүтцийн төсөлд ОТ ХХК нь Санхүүжүүлэгчтэй тохиролцсон шаардлагуудыг биелүүлэх, мөн холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн стандартуудад нийцүүлнэ. Үүнд, шаардлагатай бол, зохих байгаль орчин, нийгмийн нөлөөллийг үнэлгээг хийлгүүлэх ажил багтана.</p> <p>Хамтын ажиллагааны гэрээний дагуу ОТ ХХК-аас санхүүжилт авдаг төслүүдийн хувьд ОТ ХХК нь тухайн төслүүд холбогдох хууль эрх зүйн шаардлага болон ОТ компанийн ЭМААБООН-ийн шаардлагуудад нийцсэн байдлаар, тухайн төслийн шинж чанар болон хамрах хүрээнд тохируулж, ЭМААБООН-ийн эрсдэлүүдийг авч үзэж байгаа болохыг баталгаажуулахад чиглэн ажиллана. Хамтын ажиллагааны гэрээнд тусгасан эрхийнхээ дагуу ОТ компани нь холбогдох хууль тогтоомж, ОТ-н ЭМААБООН-ийн шаардлагуудад тухайн төсөл нийцэж байгаа эсэхийг хянах зорилгоор тохирох арга хэмжээг авна.</p>	ОТ ХХК-аас санхүүжүүлэх, эсвэл ажиллуулах, холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн стандартын дагуу боловсруулсан БОННУ-д тусгагдаагүй байгаа аливаа дэд бүтцийн төслийн хувьд, тухайн төслийн барилгын ажил эхлэхээс өмнө уг төслийн БОННУ-г (БОННБДА баталсан байх) дор хаяж 60 хоногийн өмнө нийтэд мэдээллэсэн байх ёстой.
ХЭРЭГЖСЭН БӨГӨӨД ШИНЭЧЛЭГДСЭН ЗҮЙЛС			
3.	Ашиглалтын үе шатны менежментийн төлөвлөгөө (АУШМТ)	ОТ ХХК холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын ⁷ дагуу Ашиглалтын үе шатны менежментийн төлөвлөгөөг БОННБДА-д хүргүүлж хянуулна. БОННБДА нь тухайн Ашиглалтын үе шатны Байгаль орчин нийгмийн менежментийн төлөвлөгөөний бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл	ДУУССАН

⁷ Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Зээлдүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартуудыг” Төслийн БОННУ-ний холбогдох хууль тогтоожмийн жагсаалт гэсэн хэсэгт зааж өгнө.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2015.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0004	Хувилбар: 2.0

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
		<p>ажиллагааны стандартын шаардлагыг хангасан тохиолдолд ОТ ХХК-д баталгаажуулж мэдэгдэнэ.</p> <p>Тус төлөвлөгөө дараах сэдвүүдийг хамарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Агаарын чанарын менежмент (үүнд Хүлэмжийн хийн менежмент хамаарна); • Дуу чимээ, чичиргээний менежмент; • Өнгөн хөрсний менежмент; • Газрын тос болон шатахууны менежмент; • Биологийн төрөл зүйлийн менежмент; • Усны нөөцийн менежмент; • Хаягдал чулуулгийн менежмент; • Хог хаягдлын менежмент; • Тээврийн менежмент; • Аюултай материалын менежмент; • Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө; • Соёлын өвийн менежмент; • Оролцогч талуудын оролцоо; • Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны хөтөлбөр; • Шилжилт хөдөлгөөний менежмент; • Ажиллах хүчний менежмент • Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал; • Уурхайг хаах, нөхөн сэргээх ажлын менежмент; 	
4.	Уурхай хаах төлөвлөгөө	<p>ОТ ХХК холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу БОННБДА-т Уурхайг хаах төлөвлөгөөг хүргүүлнэ. БОННБДА нь тухайн Уурхай хаах төлөвлөгөөний бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангасан тохиолдолд ОТ ХХК-д баталгаажуулж мэдэгдэнэ.</p> <p>Монгол Улсын хууль тогтоомжид заасан мэдээлэл шинэчлэх хуваарийн дагуу цаашид мэдээллийг шинэчилнэ. Тухайн үед хийх аливаа нэмэлт өөрчлөлтийн Ашиглалтын үе шатны Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөтэй нийцүүлсэн байх шаардлагатай.</p>	ДУУССАН
5.	Ажилчдын байр орон сууц барьж байгуулах	ОТ ХХК Ханбогд сумын усны хангамжийг сайжруулна. ОТ ХХК усны нөөцийн үнэлгээний судалгааны мэдээлэл бэлэн болсны дараа орон нутгийн оролцогч талуудтай санал болгож	Усны хангамжийн боломжит хувилбарын талаарх тайланг

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2015.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0004	Хувилбар: 2.0

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
		<p>буй усны хангамжийн талаар зөвшилцөж, бусад зохих оролцоог Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу хангана. Уг ажилд үндэслэн, ОТ ХХК усны хангамжийн боломжит хувилбарын талаарх тайлангийн төслийг БОННБДА-т хүргүүлнэ.</p> <p>ОТ ХХК Ажилчдын байр орон сууцыг барьж байгуулах БОННУ-г холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандарт болон Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хуулийн⁸ дагуу боловсруулж БОННБДА-т хүргүүлнэ. Үүнд Засгийн газартай тохиролцсон талбайн баталгаажуулалтыг Санхүүжүүлэгчээр хянуулж, батлуулах ажил орно.</p> <p>Ханбогд сумын иргэдийн усны хангамж олон ажилчдын орон сууцны барилгын ажилтай холбогдуулан биологийн төрөл зүйл болон экосистемийн үйлчилгээнд (жишээ нь: малчдын худаг) үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээг Ажилчдын байр орон сууцыг барьж байгуулах ажлын БОННУ-нд дэлгэрэнгүй байдлаар тусгана.</p> <p>БОННБДА-т нь Ажилчдын байр орон сууцыг барьж байгуулах БОННУ-н бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагуудтай нийцсэн тохиолдолд баталгаажуулж, ОТ ХХК-д мэдэгдэнэ.</p> <p>ОТ ХХК Ажилчдын байр орон сууц барьж байгуулах БОННУ-г холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу баталгаажуулсан байдлаар олон нийтэд мэдээлнэ.</p>	<p>Ажилчдын байр орон сууцыг барьж байгуулах ажлын БОННУ-г БОННБДА-р хянуулахаар явуулахаас өмнө 30 хоногийн өмнө хүргүүлнэ.</p> <p>БОННБДА-ын баталсан Ажилчдын байр орон сууцыг барьж байгуулах ажлын БОННУ-нд заасан газарт барилгын үйл ажиллагааг эхлүүлэхээс 60 хоногийн өмнө Цахилгаан станцын БОННУ-г олон нийтэд мэдээлнэ.</p> <p>ОТ ХХК БОННБДА-ын баталсан Ажилчдын байр орон сууц барьж байгуулах ажлын БОННУ-д заасан газарт барилгын үйл ажиллагааг эхлүүлэхээс 60 хоногийн өмнө Ажилчдын байр орон сууц барьж байгуулах ажлын БОННУ-г олон нийтэд мэдээлнэ. Үүнд холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин нийгмийн үйл ажиллагааны стандартуудад нийцэж байгаа эсэхийг шалгах БОННУ-ийн өөр бусад процессоор хараахан ороогүй Ажилчдын орон сууц барьж байгуулахтай холбоотой шинэ дэд бүтцийн байгууламжууд (шугам хоолой, цахилгааны шугам, зам гэх мэт)-ыг оруулна.</p>
6.	Аж үйлдвэрийн парк	ОТ ХХК нь холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандарт, Байгаль орчин болон нийгмийн үйл ажиллагааны хуулийн, ⁹ дагуу боловсруулсан Аж	ОТ ХХК БОННБДА-ын баталсан Аж үйлдвэрийн парк барьж байгуулах

⁸ Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Байгаль орчин ба нийгмийн үйл ажиллагааны” холбогдох хууль тогтоомжуудыг Ажилчдын байр орон сууц барьж байгуулах БОННУ-ний холбогдох хууль тогтоомжийн жагсаалт гэсэн хэсэгт зааж өгнө.

⁹ Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны” холбогдох хууль тогтоомжуудыг Аж үйлдвэрийн парк байгуулах БОННУ-ний холбогдох хууль тогтоомжийн жагсаалт гэсэн хэсэгт зааж өгнө.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2015.11.20	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0004	Хувилбар: 2.0

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
		<p>үйлдвэрийн парк барьж байгуулах БОННУ-г БОННБДА-т хүргүүлэн Санхүүжүүлэгчээр хянуулж, батлуулна. Аж үйлдвэрийн парк барьж байгуулахтай холбогдуулан биологийн төрөл зүйл болон экосистемийн үйлчилгээнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээг дэлгэрэнгүй байдлаар БОННУ-нд тусгана.</p> <p>БОННБДА нь Аж үйлдвэрийн парк барьж байгуулах БОННУ-н бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагуудтай нийцсэн тохиолдолд баталгаажуулж, ОТ ХХК-д мэдэгдэнэ.</p> <p>ОТ ХХК Аж үйлдвэрийн парк барьж байгуулах БОННУ-г холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын дагуу баталгаажуулсан байдлаар олон нийтэд мэдээлнэ.</p>	БОННУ-д заасан газарт барилгын үйл ажиллагааг эхлүүлэхээс 60 хоногийн өмнө Аж үйлдвэрийн парк барьж байгуулах БОННУ-г олон нийтэд мэдээлнэ. Үүнд холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин нийгмийн стандартуудад нийцэж байгаа эсэхийг шалгах БОННУ-ийн өөр бусад процессоор хараахан ороогүй Ажилчдын орон сууц барьж байгуулахтай холбоотой шинэ дэд бүтцийн байгууламжууд (шугам хоолой, цахилгааны шугам, зам гэх мэт)-ыг оруулна.
11.	Оюу Толгойгоос Ханбогд сумын төв хүртэлх цахилгаан дамжуулах шугам	<p>ОТ ХХК Оюу Толгойгоос Ханбогд сумын төв хүртэлх цахилгаан дамжуулах шугамын байгаль орчин, нийгмийн үнэлгээг (Цахилгаан дамжуулах шугамын үнэлгээ) БОННБДА-т хүргүүлнэ.</p> <p>БОННБДА нь тухайн Цахилгаан дамжуулах шугамын үнэлгээний бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулна.</p> <p>Цахилгаан дамжуулах шугамын үнэлгээг батлуулж, олон нийтэд мэдээлнэ.</p>	ДУУССАН
12.	Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх замын чиглэл өөрчлөх	<p>ОТ ХХК нь Оюу Толгойгоос Гашуун Сухайт хүртэлх замын түр өөрчлөгдсөн чиглэлийн Байгаль орчин, нийгмийн үнэлгээг (Замын чиглэл өөрчилсөн талаарх үнэлгээ) БОННБДА-т хүргүүлнэ. БОННБДА нь тухайн Замын чиглэл өөрчилсөн үнэлгээний бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулна.</p> <p>ОТ ХХК Замын чиглэл өөрчилсөн үнэлгээг баталсан байдлаар олон нийтэд мэдээлнэ.</p>	ДУУССАН
13.	Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх	<p>ОТ ХХК дараах зүйлсийг харгалзан үзэж, шинэчилсэн Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг БОННБДА-т хүргүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Төсөл болон тэдгээрийн нөлөөллийн талаарх сүүлийн үеийн мэдээлэл; - Шинэчилэн нөхөн олговрын журам; - Бэлчээрийн менежмент ба амьжиргааг сайжруулах стратеги; 	ДУУССАН

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2015.11.20Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0004Хувилбар:
2.0

Д/д.	Авах арга хэмжээ	Авах арга хэмжээний тодорхойлолт	Ажлыг гүйцэтгэж дуусгах хугацаа
		<ul style="list-style-type: none">- Оролцогч талуудын оролцооны талаарх үйл ажиллагааны үр дүн, үүнд “Гомдол санал шийдвэрлэх баг”-ийн процесс хамаарна (боломжтой буюу хамааралтай бол);- Хамтын ажиллагааны гэрээ (боломжтой буюу хамааралтай бол);- Төлөвлөсөн төрөл бүрийн нийгэм эдийн засгийн үнэлгээ болон 2014 онд гүйцэтгэж дуусгах нөхөн олговрын хөтөлбөрийн аудит. <p>БОННБДА нь тухайн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний бүх баримт бичиг холбогдох Санхүүжүүлэгчийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын шаардлагын хангасан тохиолдолд баталгаажуулж ОТ ХХК-д мэдэгдэнэ.</p> <p>ОТ ХХК батлагдсан Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд мэдээлнэ.</p>	